

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-13
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	14-44
1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Тогтоолд өөрчлөлт оруулах тухай/	14-15
2.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд/Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	15-35
3.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	35-38
4.Хууль тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан	38-44

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 05 дугаар сарын 06-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Б.Мөнхсоёл;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Баттулга, М.Мандхай;

Тасалсан: Ж.Ганбаатар, О.Цогтгэрэл, С.Цэнгүүн.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Тогтоолд өөрчлөлт оруулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Тогтоолын төслийн талаар Байнгын хорооны дарга Р.Сэддорж танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Р.Сэддорж: “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 3

Бүгд: 16

81.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Хуралдаан 10 цаг 05 минутаас 12 цаг 20 минутад түр завсарлав.

Хоёр.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монголбанкны Дэд

ерөнхийлөгч Г.Энхтайван, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Батцэцэг, мөн газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт Х.Сүрэнхорол, Салбарын бодлого, зохицуулалтын референт Б.Золбоо, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Цагдаагийн ерөнхий газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга С.Тайван, Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Монополын эсрэг газрын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, зар сурталчилгааны газрын дарга Ц.Тэрбиш, Харилцаа холбооны зохицуулах хорооны Ажлын албаны дарга А.Лувсан-Очир, мөн хорооны Зохицуулалтын газрын дарга Т.Батболд, Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал С.Гантулга, мөн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн профессор Л.Бат-Очир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нар танилцуулав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн тавьсан асуултад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг хуулийн төслийн хэлэлцүүлгийг 7 хоногийн хугацаатай хойшлуулъя гэсэн горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	5
Татгалзсан:	13
Бүгд:	18

27.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	11
Бүгд:	18

38.9 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж Улсын Их Хурлын гишүүн Ч.Анараас хуулийн төслийг бүхэлд нь буцаая гэсэн горимын санал ирүүлснийг танилцуулав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	0
Татгалзсан:	18
Бүгд:	18

0.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг хуулийн төслийг хэлэлцэхийг хойшлуулж, дахин ажлын хэсэг гаргаж хэлэлцье гэсэн горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	11
Бүгд:	18

38.9 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Нэг.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Д.Ганбат, П.Сайнзориг, Х.Ганхуяг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	5
Татгалзсан:	13
Бүгд:	18

27.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	10
Бүгд:	18

44.4 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 9
Бүгд: 18
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

11.4.спорт бооцоот тааврын үйл ажиллагаа эрхлэх Тайлбар: “спорт бооцоот таавар” гэж оролцогч болон зохион байгуулагчийн аль аль нь үр дүнг нь урьдчилан мэдэх, эсхүл үр дүнд нь нөлөөлөх боломжгүй спортын тэмцээн, цахим спортын тэмцээн, уралдааны талаар үр дүнг тааварлаж тогтоосон дүрмийн дагуу бооцоо тавих үйл ажиллагааг ойлгоно.	Биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
---	---

гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19

52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	9
Бүгд:	19

52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг үг хэлж, саналаа тайлбарлав.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: Төслийн нэрийн “нэмэлт,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	7
Бүгд:	19

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хамт өргөн мэдүүлсэн:

Нэг.Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлж, саналаа тайлбарлав.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: 1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Эрүүгийн хуульд доор дурдсан агуулгатай 20.18, 20.19 дүгээр зүйл нэмсүгэй:

“20.18 дугаар зүйл.Бооцоот таавар зохион байгуулах

1.Эрх бүхий байгууллагын олгосон зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээс бусад хэлбэрээр оролцогч болон зохион байгуулагчийн аль аль нь үр дүнг нь урьдчилан мэдэх, эсхүл үр дүнд нь нөлөөлөх боломжгүй үйл явдлын үр дүнг тааварлаж, тогтоосон дүрмийн дагуу бооцоо тавьдаг бооцоот тааврыг ашиг олох зорилгоор олон нийтийн газар болон мэдээллийн технологи ашиглан зохион байгуулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

20.19. дүгээр зүйл.Мөрийтэй тоглоом, бооцоот таавар зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх

1.Мөрийтэй тоглоом зохион байгуулах, эсхүл хууль бусаар бооцоот таавар зохион байгуулах гэмт хэргийн үйлдэлд өөрийн, эсхүл бусдын нэр дээрх төлбөр тооцооны данс, цахим мөнгө, виртуал хөрөнгө, харилцаа холбооны сүлжээний дугаар, цахим тодорхойлогчийг удаа дараа ашиглуулах замаар дэмжлэг үзүүлсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	9
Бүгд:	19

52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийг дэмжсэнээр тооцож, 57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хоёр.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлж, саналаа тайлбарлав.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: 1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 10.1 дүгээр зүйлийн 6, 7 дахь хэсгийн “Төлбөрт таавар, эсхүл бооцоот тоглоом” гэснийг “Мөрийтэй тоглоом, эсхүл хуулиар зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бооцоот тааврыг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	10

Бүгд: 19
47.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Р.Сэддорж: 1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 10.1 дүгээр зүйлийн 6, 7 дахь хэсгийн “Төлбөрт таавар, эсхүл бооцоот тоглоом” гэснийг “Мөрийтэй тоглоом, эсхүл хуулиар зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бооцоот тааврыг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 10
Бүгд: 19
47.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 8
Бүгд: 19
57.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Р.Сэддорж: 1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 10.1 дүгээр зүйлийн 6, 7 дахь хэсгийн “Төлбөрт таавар, эсхүл бооцоот тоглоом” гэснийг “Мөрийтэй тоглоом, эсхүл хуулиар зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бооцоот тааврыг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 10
Бүгд: 19
47.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Р.Сэддорж: 1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 10.1 дүгээр зүйлийн 6, 7 дахь хэсгийн “Төлбөрт таавар, эсхүл бооцоот тоглоом” гэснийг “Мөрийтэй тоглоом, эсхүл хуулиар зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бооцоот тааврыг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: 1.Төслийн 2 дугаар зүйлийн “нэмэлт,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гурав.Зар сурталчилгааны тухай нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн “төлбөрт таавар” эс үгүй бол “бооцоот тоглоом” эсвэл “мөрийтэй тоглоомыг” гэснийг “мөрийтэй тоглоом” эс үгүй бол “бооцоот тааврыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 8

Бүгд: 19
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: 2.Төслийн 2 дугаар зүйлийн “нэмэлт,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Дөрөв.Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг саналаа тайлбарлав.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: 1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1 дүгээр зүйл. Онцгой албан татварын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “төлбөрт таавар, бооцоот тоглоомын” гэснийг “спорт, бооцоот, тааврын” гэж, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсгийн “төлбөрт таавар, бооцоот тоглоомын” гэснийг “спорт бооцоот тааврын” гэж, “5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн 3.4 дэх заалтын дугаарыг” “1.2” гэж тус тус өөрчилсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 10
Бүгд: 19
47.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг үг хэлж, саналаа тайлбарлав.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: 1.Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 12
Бүгд: 19
36.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг саналаа тайлбарлав.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: 1. Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчилсүгэй:

2 дугаар зүйл. “Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн 1.2 дахь заалтыг тус тус хүчингүй болгосонд тооцсугай” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгээс Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Б.Жаргалан завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар ажлын 5 өдрийн завсарлага авав./13:43/

Уг асуудлыг 13 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Монголбанкны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэн, мөн банкны Банкны санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал Ө.Мөнх-Ундарга, Зээлийн мэдээллийн албаны дарга, ахлах хянан шалгагч Л.Дөлгөөн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Л.Батмөнх, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн

танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т “нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн” гэж заасны дагуу санал хураалт явуулав.

Нэг.Зээллийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Р.Сэддорж: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

14.3.Олон улсын жишиг, зарчмыг баримтлан Монголбанкнаас баталсан нөхцөл, шаардлагыг үндэслэн энэ хуулийн 14.1.3-д заасан зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэл, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг тогтооно гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	14
Татгалзсан:	5
Бүгд:	19

73.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхланг дэмжсэнээр тооцож, 78.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Р.Сэддорж: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн “6 хүртэлх” гэснийг “5” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	6
Бүгд:	19

68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарыг дэмжсэнээр тооцож, 73.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол

Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Ч.Өнөрбаяр, мөн газрын Үнэлгээ, мониторингийн газрын дарга Д.Үүрийнтуяа, Хууль тогтоомж, тогтоол шийдвэр хариуцсан референт Ш.Бумаажав, ахлах шинжээч Б.Отгонцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алтантуяа, мөн газрын зөвлөх Б.Отгонтуяа, референт Г.Нямдэлгэр нар байлцав.

Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Ч.Өнөрбаяр нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболдын тавьсан асуултад Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Ч.Өнөрбаяр хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны гишүүд Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэв.

Уг асуудлыг 1 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 53 минут үргэлжилж, 25 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 76.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 08 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхимд 10 цаг 00 минут

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая аа.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сэддорж, Бадамсүрэн, Батболд, Батнайрамдал, Батшугар, Бямбасүрэн, Ганхуяг, Лодойсамбуу, Сайнзориг, Соронзонболд, Ундраа, Найдалаа, Энхтүвшин нарын гишүүд оролцож байна. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 56 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал.

1.Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл Байнгын хорооны 2025 оны 2 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай.

2.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Засгийн газраас 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн яаралтай, анхны хэлэлцүүлэг.

3.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл, Улсын Их Хурлын гишүүн Батшугар, 2024 оны 12 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн эцсийн хэлэлцүүлэг.

4.Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг хэлэлцэх гэсэн ийм 4 асуудал хэлэлцэхээр орж ирсэн.

Хэлэлцэх асуудалтай холбогдолтой санал, асуулт байна уу? Байхгүй байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдолтой асуулт, санал алга байна.

Хэлэлцэх асуудал дээр асуулт санал байхгүй учраас 1 дүгээр асуудалдаа оръё.

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол тогтоолд өөрчлөлт оруулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1. Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 2 дугаар тогтоолоор баталсан Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Энхбатын Болормааг нэмсүгэй гэсэн ийм тогтоол байна аа.

Зээлийн хүүг бууруулах тийм нөгөө тогтоолын хэрэгжилттэй. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Болормааг нэмж орохоор хүсэлт илэрхийлсэн бөгөөд тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Алга байна. Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа.

Тогтоолд өөрчлөх өөрчлөлт оруулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт 81.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Байнгын хорооны тогтоолын тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

10.04 цагт

Дараагийн асуудалд оръё. Хэлэлцэх асуудал 2.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эхний хэлэлцүүлгийг явуулж эхэлъе.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Хуралдааныг Улсын Их Хурлын гишүүн Ундраа үргэлжлүүлж даргалж явуулна.

А.Ундраа: Хууль санаачлагчийг хүрэлцэн ирэх хүртэл байнгын хорооны хуралтай. Хууль санаачлагчийг хүрэлцэн ирэх хүртэл Байнгын хорооны хурлыг нэг цаг завсарлууллаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя за.

Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Ганболдын Энхтайван Монголбанкны дэд ерөнхийлөгч, Нармандахын Жамъянхүү ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга, Хаш-Эрдэнийн Сүрэнхорол ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын ахлах референт, Баатарчулууны Золбоо ЗГХЭГ-ын Салбарын

бодлогын зохицуулалтын газрын референт, Тойруулын Батболд ХХЗХ-ны зохицуулалтын газрын дарга, Алтайн Лувсан-Очир ХХЗХ-ны ажлын албаны дарга, Сайнбуянгийн Тайван ЦЕГ-ын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга, Цэрэн Дэлгэрийн Тэрбиш Монополын эсрэг газрын хэрэглэгчийн эрхийг хамгаалах Зар сурталчилгааны газрын дарга, Баатарсүрэнгийн Батзориг ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга, Сэнгээгийн Гантулга Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор, Цагдаагийн хурандаа, Лувсангийн Бат-Очир Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн профессор, доктор, дэд профессор, Цагдаагийн дэд хурандаа, Цэрэнсүрэнгийн Лхагвацэнд ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Нийтийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн.

Хуулийн төслийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг уншиж танилцуулна аа.

Гишүүний микрофоныг нээе.

Х.Ганхуяг: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцэхээр Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн хуралдаанаар шийдвэрлэсэн бөгөөд хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 4 сарын 4-ний өдрийн хуралдаанаар явуулж анхны хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо болон ХЗБХ-нд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2025 оны 4 сарын 9-ний өдрийн хуралдаанаараа Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварт өөрчлөлт оруулах тухай, ААН-ийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцүүлсэн болно.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, зарчмын зөрүүтэй санал гаргаагүй бөгөөд хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлж байна аа.

Эдийн засгийн байнгын хороо, эрхэм гишүүд ээ,

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татвар тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, ХХОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, ААНОАТ-ын нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсэж байна аа.

Баярлалаа.

Р.Сэддорж: Баярлалаа. Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг уншиж танилцуулна аа. Гишүүний микрофоныг нээе.

П.Сайнзориг: Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг 2025 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хороо 2025 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Байнгын хороонд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх уг асуудлаар ажлын хэсэг байгуулах нь зүйтэй гэж үзэж Хууль зүйн байнгын хороо 2025 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 02 дугаар тогтоолоор хуулийн төслүүдийг хэлэлцүүлж бэлдэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Уянгахишигээр ахлуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, П.Сайнзориг нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ажлын хэсэг 2024 оны 4 дүгээр сарын 11, 14-ний өдөр тус тус хуралдаж Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг бэлдэхтэй холбоотой тусгайлан танилцуулгыг Байнгын хорооны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанд танилцуулсны дагуу Байнгын хороо хуулийн төслүүдтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хурлын Тамгын газрын хууль зүйн дүгнэлт гаргуулах, түүнчлэн Монгол Улсын ХЭҮК, Улсын Дээд шүүх, УЕП-оос хуулийн төслүүдтэй холбогдуулан санал авахаар шийдвэрлэж холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.

ХЗБХ 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хороонд танилцуулж байна.

Нэгдүгээрт. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөс төлбөр таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэхийг хориглохоор тусгасан зохицуулалтыг хасах. Спорт бооцоот тааврын зөвшөөрөлтэй эрхлэх асуудлыг хуулийн төсөлд тусгах.

Гуравт, хуулийн эрх бүхий байгууллагын олгогдсон зөвшөөрөлтэй эрхлэхээс бусад хэлбэрээр бооцоот тааврын үйл ажиллагаа эрхийг гэмт хэрэгт тооцохоор Эрүүгийн хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг Эрүүгийн хуулийн 20.8 дахь хэсэг болгон тусгах, олон нийтийн газар эсвэл мэдээлэл, технологи ашиглан мөрийтэй

тоглоом зохион байгуулах эсвэл ашиг олох зорилгоор хууль бусаар бооцоот таавар зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн гэмт хэрэгт тооцохоор Эрүүгийн хуулийн 20.19 дэх хэсэг болгон тусгах, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгжих хугацааг 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөх. Энэ хасагдчихсан байх ёстой. Уучлаарай энэ манай Байнгын хорооны санал, дүгнэлт дээр алдаа гарсан байна. Энэ дагаж мөрдөх хугацааг ажлын хэсгээс татаж авсан.

Спорт бооцоот үйл ажиллагаанд зөвшөөрөл авсны үндсэн дээр эрхлэхийг Зөвшөөрлийн хуульд өөрчлөлт оруулахаа тусгахтай холбогдуулан Зөрчлийн тухай хууль, Зар сурталчилгаа, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хуулиудад өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийн нэр томьёог нийцүүлэн өөрчлөх. Хувь хүний орлогын албан татварын хуулиар Монгол Улсын иргэнд гадаад улсад төлбөрт таавар, бооцоот тоглоом, бооцоот таавраас олсон орлогыг татвар төлөх үүрэгтэй учир татвар ногдох орлогоо оновчтой тогтоох. Түүнчлэн Онцгой албан татварын тухай хуулийн төсөлд спорт бооцоот тааврын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой татвар ногдуулах биет хэмжээний төрөл, татварын хэмжээ тогтоох асуудлыг нарийн тооцож хуульчлах шаардлага байх тул мэргэжлийн байгууллагуудын саналыг авсны үндсэн дээр хуулийн төсөлтэй холбоотой саналыг бэлдэх зэрэг болно. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Алтанхуяг хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томьёололтой холбогдуулан асуулт асууж, хариулт авсан болно.

Зөвшөөрлийн хуульд нэмэлт оруулалт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Зөвшөөрлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Р.Сэддорж: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийг баримтлан хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ.

Мөн хуулийн 39.11 дэх хэсэгт заасны дагуу гишүүд тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асуух боломжтой.

Ганхуяг гишүүн горимын санал гаргана. Гишүүний микрофон.

Х.Ганхуяг: 2025 оны 4 сарын 4-ний өдөр чуулганы нэгдсэн хуралдаанаар тус хуулийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг дэмжсэн байгаа. Тэгээд хэлэлцэх эсэхээ дэмжээд Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн. Ингэхдээ татвартай холбоотой асуудлуудын Төсвийн байнгын хороо, Эрүүгийн хуультай холбоотой асуудлыг нь ХЗБХ дүгнэлтүүдээ хүргээд Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэх ёстой байсан, 1 дүгээр асуудал.

Үзэл баримтлалын хүрээнд энэ хуулийг 2 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох хориглох ийм үзэл баримтлалтайгаар өргөн баригдсан байдаг. Хэлэлцүүлгийн явцад нэг зөвшөөрөл нэмэхээр орж ирсэн байдаг. Тэгээд 1 дүгээр асуудал болохоор бид нар хэд хэдэн асуудал үүсчээд байгаа юм аа. Байнгын хорооны эрхлэх асуудлынхаа хүрээнд тухайн хуулийн хэлэлцүүлэг хийх ёстой. Нэг ёсондоо Хууль зүйн байнгын хороо бол тэр эрүүгийн зөрчлийн асуудлууд дээр санал, дүгнэлтээ гаргаад тэрэн дээрээ нэмэлт, өөрчлөлт оруулах оруулаад наашаа өгөх ёстой байсан. Одоо Төсвийн байнгын хороо татвар дээрээ санал, дүгнэлтээ гаргаад өгсөн.

Тэгээд нэг ёсондоо Байнгын хорооны хамрах асуудлын хүрээнд байхгүй асуудал дээр санал хураалт хийгээд ажлын хэсэг байгуулаад өнөөдөр ингээд хүргүүлж байгаа байхгүй юу. Тэгэхээрээ хуулийн анхны болон эцсийн хэлэлцүүлгийг тухайн үзэл баримтлалынхаа хүрээнд аль Байнгын хороо энэ дээр жишээлбэл санал хураалт хийж явах юм. Одоо энэ ХЗБХ-ны санал хураалт хийхдээ ороод ирчихсэн. Алийг нь чуулганд танилцуулах юм. Одоо өнөөдөр бид нар дахиад санал хураалт хийх гэж байна. Энэ Улсын Их Хуралд анхных удаа болж байгаа тохиолдол шүү. Тэгээд энэ зөвшөөрөл нэмэх асуудал Зөвшөөрлийн хуулиараа процессын дагуу энэ нийтийн сонсгол хийх ёстой.

Зөвшөөрлийн хуулиар орох ёстой. Тэгж байж Засгийн газраас өргөн барих ёстой. Эсвэл хууль санаачлагч өргөн барих ёстой. Тэгээд энэ процессыг бүгдийг нь алгасаад өнөөдөр ингээд нэг зөвшөөрөл нэмэх асуудал ороод ирж байгаа юм. Яах вэ би энэ зөвшөөрлийг байх ёстой, байх ёсгүй гэхээсээ илүү бид нар 1 дүгээрт Зөвшөөрлийн хууль өөрөө процессын хууль юм. Энэ процессын дагуу зөвшөөрөл олгоно шүү. Ийм процессын дагуу зөвшөөрлийг нэмнэ шүү гээд хуульчилчихсан байхгүй юу. Тэгээд өнөөдөр бид нар Дэгийн тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль ингээд бүх хуулиудаа ингээд хойш нь тавьж байгаад ингээд зөвшөөрөл нэмэх асуудлуудыг яриад ороод ирж байгаа юм л даа. Спорт бооцоот тоглоом онцгой дэглэмээр тухайн салбарынхаа хуулиар онцгой дэглэмээр үйл ажиллагаа явуулах ёстой байдаг юм. Ихэнх оронд бол дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт аль эсвэл тендерээр нэмдэг, зөвшөөрлийг нь олгодог ийм төрлийн. Мөн онцгой татвартай байдаг төрөл. Мөн дүрийн онцгойг хяналт дор явуулдаг үйл ажиллагаа байхгүй юу. Тэгээд өнөөдөр энэ салбарын хууль нь байхгүй байхад ингээд ороод ирэхээр яах вэ гэхээр өмнө Учрал сайд ч гэсэн мэдэж байгаа. Өмнө нь энэ Зөвшөөрлийн хуулийг батлуулж байхад энэ бооцоот тоглоомтой холбоотой асуудал дээр салбарын хууль нь орж иртэл нь нэг ч зөвшөөрөл олгож болохгүй шүү гээд протоколд тусгасан байхад Дээд шүүхээс шүүхдэж байгаад шүүхийн шийдвэрийн дагуу хэдэн тооны зөвшөөрөл олгосон байдаг.

Тэгээд бодвол Дээд шүүх бол үндсэндээ бид нарын протоколд байсан юмыг нь зөрчөөд өнөөдөр бас яг бид нар энэ үүд хаалгыг нь дахиад л нээх гээд л явж байгаа байхгүй юу. Тэгээд миний горимын санал юу вэ гэхээр спорт бооцоотой холбоотой энэ зөвшөөрөлтэй холбоотой энэ хуулийг манай Сайнзориг гишүүн өргөн барихад бэлэн болчихсон байсан юм. Нийтийн сонсголоо ч хийгээд хэлэлцүүлгүүдээ ч хийгээд. Тэгэхээр энэ асуудлыг би нэг 7 хоногоор хэлэлцүүлэхийг хойшлуулаад тэр хооронд Сайнзориг гишүүн хуулиа өргөн бариад тэгээд хамтруулаад хэлэлцүүлээд явахгүй бол яг энэ байдлаараа явбал бид нар үндсэндээ Улсын Их Хурлын бүрэн эрхэд халдаж байна. Эдийн засгийн байнгын хорооны

бүрэн эрхэд халдаж байна. Олон хуулиудыг зөрчиж энэ хуулийг бид нар цаашаа хэлэлцэх эсэх нь явж байна гэсэн үг. Тэгээд энэ дээр би та бүхнээс дэмжиж хүсэж байна аа.

Р.Сэддорж: Сайнзориг гишүүний микрофон өгье.

П.Сайнзориг: Би Ганхуяг гишүүний хэлж байгаа энэ санаа зовнил болгоомжлолыг ойлгож байна аа. Тэгэхдээ хэдүүлээ дэгийн хууль зөрчигдсөн мэтээр ярьж болохгүй байх аа. Энийг дагасан Эрүүгийн хууль Зөрчлийн хуулийг хэлэлцээд тэндэх агуулга өөрчлөгдөхөд угаасаа Зөвшөөрлийн хуулийн агуулга өөрчлөгдөхөөс өөр арга байхгүй. Өөрөөр хэлэх юм бол тодорхой үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцох, тооцохгүй асуудал байгаа. Бид ХЗБХ-н дээр гарсан ажлын хэсэг бол зөвшөөрлийг нэмээгүй, 2 зөвшөөрөл хасах гэж байсныг нэгийг нь үлдээсэн л ийм л асуудал байгаа. Тэрнээс биш зөвшөөрөл нэмээд байгаа зүйл ерөөсөө байхгүй. Засгийн газраас өргөн барьсан энэ хуулийн төсөл дээр Зөвшөөрлийн хууль дээр хориглох заалт нэмж байгаа нь угаасаа Зөвшөөрлийн хуулийн зорилго зохицуулалтад хамаагүй зүйлийг тусгажээ гэдэг зүйлийг Улсын Их Хурлын Тамгын газрын хууль зүйн дүгнэлтээр тодорхойлчихсон.

Дээрээс нь энэ уялдаа холбооны асуудал дээр бас нэлээн хүндрэлтэй зүйлүүд байна гэдэг зүйлийг тодорхойлчихсон. Хөндөж орж ирэх ёстой 20.17 дахь заалт хөндөгдөөгүй. Энэнээсээ шалтгаалаад бас энэ хууль зүйн асуудал үүсэж байгаа гэдгийг тодорхойлчихсон. Ийм л зүйл байгаа. ХЗБХ тэгээд Засгийн газрын барьсан энэ төслийг агуулгын хүрээнд нь дэмжээд энэ хориглох үйл ажиллагааны тодорхой хэсгийг л ч буцааж байсан хэмжээнд нь үлдээж байгаа болохоос цоо шинэ юм нээгээгүй шүү. Энэ спорт чинь одоо ч нээлттэй байгаа. Энийг нь хориглоод бусад тэр казино болон казиногийн төрлийн тоглоом спортоос бусад үйл ажиллагаан дээр БЭТ тавихыг л хязгаарлаж, агуулгыг нь зүгээр хумьж орж ирсэн болохоос биш ерөөсөө байгаа зүйл дээр бид хэд юм нэмээгүй. Тэгэхээр энэ Засгийн газраас өргөн барьсан хуулийн концепцын үзэл баримтлалын хүрээнд байгаа гэдэг зүйлийг хариуцлагатай хэлье.

Хоёрдугаарт харин Зөвшөөрлийн хуулийн энэ концепцыг бид нар Хууль зүйн байнгын хороо авч гарч хориглосон заалтыг тэр хууль дээр тусгахгүйн тулд ийм зүйлүүдийг авч томьёоллуудыг бэлтгэсэн гэдэг зүйлийг хэлье. Тэгээд би Эдийн засгийн байнгын хорооны гишүүн. Тэгэхдээ Эдийн засгийн байнгын хорооны дарга бас анхаармаар байна. Ийм зүйлүүд дээр ажлын хэсэг гаргахгүй. Эдийн засгийн байнгын хороо өөрөө ажлын хэсэг гаргахгүй асуудлуудыг ингэж хөнгөн хандаж одоо ингээд тэнд асуудалд нухацтай хандсан ХЗБХ-г буруутгаж бас ерөөсөө болохгүй байхгүй юу. Энэ чинь энэ хуулийг хэрэвзээ батлагдах юм бол уяачдаасаа эхлээд энэ спортыг дагаж хөгжүүлж байгаа бүх хүмүүс чинь бүгд эрүүгийн хариуцлагад дуудагдана шүү дээ. Ийм л зүйл байсан. Хамгийн түрүүнд хэдэн уяачид бооцоо тавьж уралдаж байгаа хүмүүс бүгд энэ хавартаа багтааж эрүүгийн хариуцлага хүлээх тийм бололцоо байгаа шүү. Энэ үр дагаврыг нь л бид нар тооцож бас энэ уламжлалт морин спорт, энэ спортын эдийн засаг гэж байдаг. Энэ эдийн засаг багийн спортыг дагаад ч юм уу тодорхой энэ бооцоот асуудлыг нь зөв тайлбарлах ёстой юм байна гэж л үзсэн. Тэгээд энэ судалгаа шинжилгээг нь авч үзэх юм бол энэ спортод энэ мөнгө алдаад байгаа зүйл байхгүй юм байна лээ.

Спортын тэр сайт гээд нэрлэгдээд байгаа тэр ван экспертүүд дамжаад казинод мөнгө алдаад байгаа юм байна лээ. Ерөөсөө л энэ. Тэгээд бид казиног нь

бүрэн хориглоё гэж байгаа юм. Тэгээд ийм зүйл байгаа шүү. Тэгээд би яах вэ Ганхуяг гишүүний.

Учрал сайдын микрофоныг нээе.

Н.Учрал: Засгийн газраас өргөн мэдүүлсэн хууль бол цахим мөрийтэй тоглоом, төлбөрт таавар, бооцоот тоглоомыг зохион байгуулах, тоглох, зуучлах, дэмжлэг үзүүлэх, сурталчлах, бүх үйлдлийг бүхэлд нь хориглох л зорилгоор Зөвшөөрлийн хуульд байсан 2 зөвшөөрлийг одоо энэ Зөвшөөрлийн хуулиас авч хаяад буюу бүхэлд нь хориглоё гэсэн зөвшөөрлийг нэмэгдүүлээгүй. Зөвшөөрлийн тоог бууруулсан. Яах вэ Их Хурлын ажлын хэсэг мэдээж ажиллаад энэ 2 зөвшөөрлийг бол энэ Зөвшөөрлийн хуулиас авч байгаа нь зөв юм байна аа. Гэхдээ яг энэ спорт төлбөр, таавар буюу нөгөө урьдчилан үр дүнг нь мэдэх боломжтой үр дүнд нь нөлөөлөх боломжгүй спортын тэмцээн, уралдааны талаар тусгай зөвшөөрөлтэй үлдээе гэдэг энэ санал санаачилгыг гаргаад явж байгаа гэж би ойлгож байгаа.

Тэгэхээр Их Хурлын ажлын хэсгийн энэ бол санал. Тэгэхээр мэдээж энийг Их Хурал шийднэ. Засгийн газрын хууль бол өөрөө бүхэлд нь цахим мөрийтэй тоглоомыг хориглоё л гэдэг хууль шүү. Яагаад тухайн үед спорт төлбөр тааврыг үлдээж болохгүй бүхэлд нь хориглоё гэсэн бэ гэхээр спорт бооцоот тоглоом гэдэг нэрийн дор цахим мөрийтэй тоглоомын шинж агуулсан үйлдэл үйл ажиллагааг зохион байгуулагддаг, сурталчилдаг, дэмжлэг үзүүлдэг үйлдлүүд тогтоогдоод байна гэж. Гүйцэтгэх засаглал бол ажлаа хийе гэхээр энэ төрийн албан хаагч нарыг наад мөрийтэй тоглоом дээр анхаарал тавь, ажилла гэхээр өөдөөс хууль яриад байгаа юм аа.

Тийм учраас нэн яаралтай горимоор барьсан юм. 4 дүгээр сарын 4-ний өдөр Их Хурал хэлэлцэх эсэхээ яг дэмжсэн өдөр 5 дугаар сарын өнөөдөр 6-ны өдөр энэ хооронд 16.6 сая ам.доллар зөвхөн энэ Ван экспедер чинь гарчихлаа. Тэгэхээр нөгөө Их Хурал ажлын хэсэг байгуулаад анхааралтай ажигласаар байтал энэ олон айл өрхийн амьдрал хүнд боллоо шүү дээ. Тэгээд энэ 7, 7 хоногоор сунгаад байх нь бид нарт нэг их асуудалгүй юм шиг мөртөө цаанаа энд нөгөө нэг агуулга нь аягүй том байна. Засгийн газар ажлаа хийхэд.

Тийм учраас зүгээр хурдан хугацаанд энэ хуулийг гаргаад хуулийнх нь дагуу ажлаа хийх энэ дээр хязгаарлах боломж бололцоог энэ төрийн албан хаагч нарт олгож өгөөч л гэж би хүсэж байна. Гэхдээ энэ хэрвээ ажлын хэсгээс гаргасан санал дэмжигдээд ингээд явбал үүн дээр Сайнзориг гишүүний хуулийг яаралтай оруулж ирээд хэлэлцээд явж байх хооронд зөвшөөрөл олгогдохгүй байх эрх зүйн зохицуулалттай.

Дээрээс нь зөвшөөрлийн зөвлөлийг ахалж байгаагийнхаа хувиар миний зүгээс зөвшөөрлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслээд Хууль зүйн яаманд яг одоо бичиг хүргүүлчихсэн байгаа. 6 сард зөвшөөрөл олгох асуудал байхгүй шүү. Зөвшөөрлийн зөвлөл дүгнэлтээ гаргачихсан шүү гээд. Тэгэхээр 1 талдаа гаргаад хугацаа алдмааргүй байна л гэдэг.

Р.Сэддорж: Ганхуяг гишүүн гаргасан горимын саналтай холбогдуулж тайлбар хийе. Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Чуулганаас тэр Эдийн засгийн байнгын хороо руу шилжүүлсэн. Төсвийн байнгын хороо руу татварын асуудал дээр санал, дүгнэлтээ гаргаж өг өө гэсэн. Би Дэгийн хууль ярьж байгаа шүү. Энэ Тамгын газрынхнаас хэн байгаа юм. Тэр Тамгын газраас надаа хариулна шүү. ХЗБХ руу Эрүүгийн хууль дээр санал дүгнэлтээ гаргаж өг гэсэн. Тэгэнгүүт Төсвийн байнгын хорооноос санал, дүгнэлтээ ирүүлсэн байна татвартай холбоотойгоор. Тэгэнгүүт ХЗБХ-оос зарчмын зөрүүтэй саналууд гаргаад оруулаад ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ чинь үзэл баримтлалын хүрээнд болж байгаа юм уу? Тэгээд бид нар энэчээ дахиад тэр зарчмын хүрээнийх нь орж ирсэн саналууд дээр санал хураагаад явахаар дэгийн хууль зөрчихгүй юу болчихоод байгаа байхгүй юу даа. Тэгээд энэ дээр Тамгын газрынхан нь хариугаа өгөөрэй.

Нэг Байнгын хороогоор санал хураалт хийх ёстой шүү дээ. Тэгэхээр энэ дээр би нөгөө хэлээд байгаа юм нь нэг 7 хоног хойшлуулчихъя. Энэ 7 хоногт Сайнаа тэр хуулиа өргөн барьчих тэгээд нийлүүлээд хэлэлцээд явбал энэ юм чинь нэг жоохон юу руу очих гээд байгаа байхгүй юу. Сайнаа угаасаа тэр хууль дээрээ хэлэлцүүлгийг нь ч шийдсэн, Нийтийн сонсголыг нь ч шийдсэн. Ингэж явахгүй бол бид нар нэг юмаа хийх гэж нөгөө хүн бусад бүх хуулиудаа зөрчөөд л яваад байж болохгүй байхгүй юу даа. Энийг л хэлээд байгаа шүү дээ. Зөв буруугийн асуудал биш энэ. Алив Тамгын газар тайлбар өгөөрэй.

Р.Сэддорж: Тамгын газар тайлбар хийе. 1 дүгээр микрофон.

Ч.Дондогмаа: Ганхуяг гишүүний асуултад тайлбар өгье өө. Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.3-д нэг хуулийн төслийг хэд хэдэн Байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргахаар хууль тогтоомжид заасан бол тэдгээр нь хуралдаанаа тус тусдаа зохион байгуулж санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ гэсний дагуу Эдийн засгийн байнгын хороо нэгд хэд хэдэн Байнгын хороо буюу Хууль зүй, Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгтгэн хэлэлцэж байгаа.

Их Хурлын тухай хуулиас заасан Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл тухайн 7 хоног дахь хуваарийг батална. Энэ баталсан хуваариар Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг ХЗБХ-нд бүхэлд нь хуваарилсан. Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлээд байсан шүү дээ. Эдийн засгийн байнгын хороо болон холбогдох Байнгын хороонд шилжүүлээд Зөвшөөрлийн хуулийг болон хамт өргөн мэдүүлсэн хуультай нь хамт.

Р.Сэддорж: Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар бүхэлд нь ХЗБХ-нд шилжүүлсэн хэлэлцүүлгийг хуваарь гаргасан байгаа.

Тэгээд хуулийг шуурхай хэлэлцье гэсэн үүднээс энэ оруулж ирж байгаа. Тэгээд одоо Ганхуяг гишүүний горимын саналаар санал хураалт явагдана. Яаралтай горимоор орж ирж байгаа. Тэгээд ХЗБХ-оос ажлын хэсэг гаргасан учраас Эдийн засгийн байнгын хороо ажлын хэсэг гаргах шаардлагагүй юм байна л гэж үзсэн. Тэгээд энэ хуралдаан дээрээ.

Ингээд санал хураалт явуулъя.

7 хоногийн хойшлуулах. Сайнзориг гишүүн. Хассуурийн Ганхуяг гишүүний гаргасан горимын саналаар 7 хоног хойшлуулъя хэлэлцэх асуудлаас хойшлуулъя гэсэн саналаар санал хураалт.

Санал хураалт.

27.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. Өөр саналтай хүн байна уу? хэлэлцүүлэгтээ оръё. Анар гишүүнээс ийм санал ирсэн. Сайнзориг гишүүн микрофонгүй ярихгүй. Анар гишүүнээс Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг бүхэлд нь хууль санаачлагчид буцаах гэсэн ийм санал оруулж ирсэн, санал гаргасан. Эхлээд яг горимын хувьд бол энэ саналыг хэлэлцэж байж цаашаа явах болж байна. Ийм учраас Улсын Их Хурлын гишүүн Анарын гаргасан энэ хуулийн төслийг бүхэлд нь буцаах саналыг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна. Энэ Анар гишүүний саналтай холбогдуулж тайлбар байхгүй, тийм өөрөө байхгүй учраас.

Ингээд Сайнзориг гишүүн горимын саналаа гаргачих тэгээд цаашаа явъя.

П.Сайнзориг: Сая миний төхөөрөмж дээр хурууны хээ энэ дээр улайчихлаа дарга аа. Тийм учраас би уг нь санал гаргаад гараа өргөөд байсан харсангүй л дээ. Тэгээд Ганхуяг гишүүний горимын санал дээр хураагаад унасан саналыг хүчингүй болгоод дахин санал хурааж өгнө үү.

Р.Сэддорж: Сайнзориг гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт. Санал хураалт хүчингүй болгоё гэсэн горимын саналаар санал хураалт.

38.9 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Ингээд Анар гишүүний гаргасан бүхэлд нь хууль санаачлагчид буцаах гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт. Одоо гишүүд анхааралтай санал хураалтад оролцоорой. 10 гишүүн байна. Тэгээд Анар гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт. Анар гишүүний гаргасан санал дэмжигдсэнгүй тэг хувь.

1.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хойшлуулахгүй гэж явсан тиймээ. Одоо ингээд шууд явчихлаа.

Горимын санал Сайнзориг гишүүн горимын санал.

Р.Сэддорж: Нээрээ энэ Эдийн засгийн байнгын хорооны дарга аа ажлаа хийвэл хий. Би улс төржиж байгаа юм биш. Наад хажуудаа сууж байгаа залуудаа ажлаа хий гэж хэл. Ийм үр дагавартай юм орж ирээд байхад ажлын хэсэг гаргахгүй. Тэгээд ингээд бусад Байнгын хорооны санал, дүгнэлт ороод ирэхээр зөрнө, зөрөхгүй, зөрчигдөнө яана гээд янз бүрийн юм болоод байх юм. Одоо тэгээд энэ дээр ажилласан хүн нь одоо Уянгахишиг гишүүн бид 2 буруутаад зөвшөөрөл нэмсэн хэрэгт орох юм байна. Мөрийтэй тоглоомыг зөвшөөрч байгаа хэрэгт орох юм байна. Хүмүүсийн ар гэрийн амьдралаар тоглох хэрэгт орох гээд байна.

Тийм учраас энэ дээрээ Эдийн засгийн байнгын хороо ажлын хэсэг гаргаж ажиллах горимын санал гаргаж байна. Ингээд эцэслэ.

Р.Сэддорж: Сайнзориг гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явагдана.

Хэлэлцүүлгийг хойшлуулж, ажлын хэсэг гаргах гэсэн ийм санал байна тийм ээ Сайнзориг гишүүнээ.

Энэ саналаар Сайнзориг гишүүний гаргасан саналаар санал хураалт.

38.9 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Дэмжсэнээр авна гэсэн ойлголт байхгүй. Горимын санал гаргаж болно. Батболд гишүүн горимын санал гаргана.

Р.Батболд: Харин тийм энэ чинь үг хэлүүлэхгүй та нар чинь хоорондоо ярьсаар байгаад энэ ХЗБХ-оос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор хэлэлцэх гээд байгаа юм уу яах гээд байгаа нь мэдэгдэхээ больчихлоо. Одоо бид нар чинь сарын өмнө хаашаа юм бэ? Энэ бооцоот таавар, энэ цахим тоглоом, мөрийтэй тоглоомыг больё гэж орж ирээд тэрийгээ хэлэлцээд байсан биз дээ. Тэгсэн чинь одоо болохоор буцаагаад спорт бооцоот тоглоом гэж орж ирээд байх юм. Энэ ямар учиртай юм бэ? Эс үгүй бол энэ Учрал сайд тэр хориглосон, тэр хуулийнхаа төслийг тат эс үгүй бол буцаагаад хэвээр нь болго энийгээ. Тэгэхгүй бол энэ чинь бүүр утгаа алдлаа. Тоглоом юм уу хаашаа юм бэ? Спорт бооцоот тоглоом гэж юугаа ойлгоод байгаа юм? Үгүй энэ чинь адилхан. Нөгөө тэр Учрал сайд таны хэлээд байгаа Ван экспед дээр чинь спорт тоглоом л явж байгаа шүү дээ. Ялгаа байхгүй шүү дээ. Цахимаар явж байгаа. Одоо тэгээд Сайнаа гишүүн чинь болохоор мориныхныг аваачиж шоронд хийнэ гээд. Үгүй сагсан дээр ч гэсэн тавимаар. Тэгээд харин тэгвэл Учрал сайд энэ Засгийн газар хуулиа тат л даа тэрийгээ боль л доо.

Аль нэгийг нь хэлж байна. Тэр Засгийн газрын тэр хорьё гэснээрээ яв, эс үгүй бол энэ дэмжсэнийг нь оруулж ирж хэлэлцсэн аль нэгийг нь хэлэлц гэж хэлээд байна шүү дээ. Нэг нь болох гээд байгаа юм шиг, нэг нь болохгүй юм шиг ийм юм яриад байх юм.

Р.Сэддорж: Техник ажиллахгүй гэсэн горимын санал гаргах л үг юм байна. Тийм. Саяын санал хураалтын талаар.

Батболд гишүүн горимын санал гаргаагүй учраас, үг хэлсэн учраас саяын санал хураалт хүчинтэй болоод явж байна аа.

Ингээд цаашаа явъя.

1.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Дахин хэлье. Гишүүд микрофон дээр үгээ хэлье.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүн байна уу? Алга байна. 1 дүгээр зүйлтэй холбогдуулж цаасаар Ганхуяг гишүүнээс санал.

Батболд гишүүн асуулт асууна. Батболд гишүүнээр тасалъя.

Р.Батболд: Би дөнгөж сая асуулаа. Энэ спорт, бооцоот таавар гэж юугаа хэлээд байгаа юм? Одоо энэ үндэслэл нь тэр нэг хэдэн уяачдыг аваачиж хийх гэж байна. Яг ялгаа байхгүй байхгүй юу. Ялгаа байхгүй. Бид нар бас сагс үзэж байгаа сагсан дээрээ тавимаар байна. Тэгэхээр очоод л болохгүй юм байна шүү дээ, наадах чинь. Тэгэхээр эсвэл Засгийн газрыг тэр хориглох гээд байгаа юмаа татаж авна л гэж би хэлээд байна шүү дээ. Угаасаа Учрал сайдад би 1 сарын өмнө хэлээд байсан. Тэр зөвшөөрлийг нь өгчихсөн вон экспид энэ тэрийг шүүхдээд зөвшөөрлөө авчхаад байгаа бол тэд нартайгаа очоод тэр татвараа тооцоод яаж авдаг юм, тэр онцгой татвар байх ёстой. Тэр 40 хувийнхаа татварыг аваад яв л даа. Бид нар энийг угаасаа хорьж чадахгүй шүү дээ. Та нар энэнд гоё юм яриад байх юм. Энэ би зүгээр алийг нь ч мэдэхгүй шүү. Тэр бооцоот таавар тэр сайттай надад таних мэдэх юм алга. Тэгэхдээ бид нар хорьж чадахгүй байхгүй юу даа чадахгүй шүү дээ энийг. Яаж хорих гээд байгаа юм. Тэгээд хорьж чадахгүй байж байж ийм юм оруулж ирчхээд дахиад нөгөөдүүл нь дахиад спорт бооцоот гэж болох юм шиг оруулж ирээд ингээд бүр толгой эргүүлээд хачин юм хийгээд байх юм.

Энийгээ л больчих л доо гээд байна шүү дээ тийм. Үгүй тэгээд яаж үлдээх юм. Нэг платформ дээр явж байгаа шүү дээ тэр чинь. Та нар яаж хорих юм. Тэрийг чинь хорьж чадахгүй шүү дээ.

Р.Сэддорж: Төслийн 1 дүгээр зүйл дээр санал гаргасан ХЗБХ-ны ажлын хэсэг Уянгахишиг, Ганбат, Сайнзориг нарын гаргасан 1 дүгээр зүйлийг хасах. Мөн Хассуурийн Ганхуяг гишүүнээс гаргасан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг хасах гэсэн саналаар хамтатгаж санал хураалт явуулна аа.

Сайнзориг гишүүн энэ дээрээ тайлбар хэлье. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Яг Батболд гишүүнийхээр л хэлж байгаа юм. Засгийн газрыг татаад аваач гээд яахаар тодорхой хэмжээнд казиногийн төрлийн тоглоомыг бид хэд угаасаа Монгол Улсад хориглож таарна аа. Тэгэхээр яг таны тэр хүсээд байгаа казиногийн төрлийн тоглоомыг ерөөсөө Монгол Улсад ерөөсөө зөвшөөрөхгүй ээ. Спорт бооцоот таавар тавих үйл явдлыг зөвхөн спортоор хязгаарлая аа. Түүнээс биш улс төрийн сонгууль дээр бооцоо тавьж болохгүй. Соёл урлагийн арга хэмжээн дээр бооцоо тавьж болохгүй. Энэ зүйлүүдийг нь хязгаарлаад зөвхөн спортын үйл явдал буюу спортын тэмцээн уралдаан дээр бооцоо тавьдаг энэ байдлыг арилгах юм бол зөвшөөрье өө үлдээчихье. Ингэх юм бол яах вэ хэдэн уяачид бооцоо тавьж уралддаг тэр байдал эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй юм байна. Эргээд хууль ёсны дагуу татвараа төлөөд явдаг энэ спортын мэргэжлийн холбоодуудтай хамтраад энэ спортын үйл явдлууд дээр бооцоо тавьдаг жижгээр тавьдаг хэмжээтэй ийм байдлаар дотоодын ААН-үүд үүсэж болох юм байна гэдэг байдлаар энэ саналыг гаргаж байгаа.

Энэ саналыг гаргасантай холбоотойгоор 1 дүгээр саналыг хасаж байж 2 дугаар санал дээрээ энэ өөрчлөн найруулах байгаа. Таны ярьж байгаа спорт бооцоот таавар гэж оролцогч болон зохион байгуулагчийн аль аль нь үр дүнг нь урьдчилан мэдэх эс үгүй бол үр дүнд нь нөлөөлөх боломжгүй спортын тэмцээн, цахим спортын тэмцээн уралдааны талаар үр дүнг тааварлаж тогтоосон дүрмийн

дагуу бооцоо тавих үйл ажиллагааг ойлгоно оо гээд дараагийн санал хураалт дээр бид нар тодорхойлж байгаа. Өөрөөр хэлэх юм бол таны үлдээе гээд байгаа тэр спортын үйл ажиллагаа буюу Засгийн газар буцаагаад энэ хэсгээ оруулж ирээч гэдэг хэсгийг чинь л бид нар ХЗБХ-оос саналыг нь гаргаад оруулж ирж байгаа шүү гэдэг зүйлийг би Батболд гишүүнд хэлмээр байна.

Тэгээд ажлын хэсгээс гаргаж байгаа энэ саналыг ХЗБХ-оос гаргаж байгаа энэ саналыг дэмжиж өгөхийг гишүүдээсээ хүсье ээ.

Р.Сэддорж: Батболд гишүүн тодруулж асууя.

Р.Батболд: Ойлгоод байна. Тэгээд яаж та нар тэр алийг нь спорт биш гэж үзээд байгаа юм? Спорт гэж яг алийгаа тооцоод байгаа юм гэдэг чинь одоо бүр сонин болчихлоо шүү дээ. Тэгээд үр дүнд нь нөлөөлөх боломжгүй. Үгүй тэгээд үр дүнд нь ямар ч юм нөлөөлөх боломжгүй шүү дээ. Одоо наадах чинь бүр тэгвэл бүр тэнэг асуудал руу орох гээд байна. Хөөе, байж бай хөөе. Та нар тэгвэл наадах чинь гаднын хэдэн бооцоот тоглоомын сайтуудыг хааж байгаад дотоодын нэг нөхөр аваачиж ийм юм үүсгэж байгаад явах гэж байгаа юм шиг бүр нэг хүний захиалгаар ийм балай юм хийж Их Хурал дээр хэрэлдүүлээд байгаа юм шиг юм болж байна шүү дээ. Хэн мэдэх юм, наадах чинь зүгээр тийм хардлага нь төрүүлчхэж байна шүү дээ. Бид нар ганцхан энэ покерыг та нар чинь тэгээд спорт гэж үзэх юм уу үзэхгүй юм уу? Үгүй тэгээд аягүй сонирхолтой юм. Үгүй покерын дэлхийн аварга болж байна гээд л тэр чинь бараг спорт маягаар л яваад байх юм байна шүү дээ. Энэ чинь тэгээд юу юм. Ингээд нэг платформ дээр явж байгаа юмыг заримыг нь хорино гэж яриад байх юм. Яаж хорих гээд байгаа юм бэ гэдгийг чинь ойлгохгүй байна.

Хэрвээ тэрийгээ зүгээр дотооддоо гэж ярьж байгаа бол наадах чинь миний яриад байгаа тэр хардлага зүгээр нэг нөхөр юу гаргах гэж байгаа юм байна. Нэг цахим тоглоомын платформ гаргах юм байна. Дотоодын хэдэн морин уралдаан сагсны тэмцээнээ оруулчих юм байна. Тэгээд тэр дотроо явах юм байна гэдэг ийм л хардлага төрүүлж байна шүү дээ.

Р.Сэддорж: Ингээд ажлын хэсгийн гаргасан санал. Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг, Сайнзориг нарын гаргасан мөн Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, мөн Хассуурийн Ганхуяг гишүүний гаргасан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг хасах гэсэн томьёоллоор.

Ингээд Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг хасах гэсэн томьёоллоор санал хураалт.

Сайнзориг гишүүн горимын санал гаргая.

П.Сайнзориг: Төхөөрөмж ажиллахгүй байна дарга. Улайгаад байна. Санал хураалтыг хүчингүй болгоод дахин санал хурааж өгнө үү.

Р.Сэддорж: Сайнзориг гишүүний гаргасан горимын саналаар. Санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалт.

44.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Батнайрамдал гишүүн горимын санал гаргая.

О.Батнайрамдал: Миний хурууны хээ сая яг энэ дээр ажилласангүй. Тэгэхээр саяын саналыг хүчингүй болгож дахин санал хурааж өгнө үү гэж горимын санал гаргаж байна аа.

Р.Сэддорж: Ингээд Батнайрамдал гишүүний гаргасан горимын санал. Сайнзориг гишүүний гаргасан горимын саналыг хүчингүй болгоё гэсэн ийм саналаар санал хураалт явуулъя аа.

Батнайрамдал гишүүний гаргасан санал хураалтаар санал хураалт.

Гишүүд танхимдаа орж ирье. Ирцэд орсон гишүүд танхимдаа.

Төслийн 2 дугаар зүйлийн зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

2 дахь санал хураалт төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1 дүгээр зүйл. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

11.4 спорт бооцоот тааврын үйл ажиллагаа эрхлэх.

Тайлбар. Спорт, бооцоот таавар гэж оролцогч болон зохион байгуулагчийн аль аль нь үр дүнг нь урьдчилан мэдэх эсвэл үр дүнд нь нөлөөлөх боломжгүй спортын тэмцээн, цахим спортын тэмцээн уралдааны талаар үр дүнг тааварлаж тогтоосон дүрмийн дагуу бооцоот тавих үйл ажиллагааг ойлгоно.

Биеийн тамир спортыг хөгжүүлэх бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг, Сайнзориг.

2 дугаар санал хураалт. Найдлаа гишүүн горимын санал гаргая гэж байна.

Б.Найдалаа: Сая үнэхээр болохгүй байна. Санал өгч чадсангүй. Энэ саналыг хүчингүй болгож өгнө үү.

Р.Сэддорж: Найдалаа гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт.

Гишүүд анхааралтай байгаарай. Гишүүд санал хураалтад идэвхтэй оролцоорой санал хураалтыг хүчингүй болгох Найдалаа гишүүний горимын саналаар санал хураалт.

52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалт хүчингүй боллоо.

2 дугаар зүйлтэй энэ биз дээ? Тийм 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Асуулт саналтай гишүүд байна уу? Алга байна.

Санал хураалт.

Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух, санал гаргах гишүүд байна уу? Асуулт алга байна, санал алга байна.

Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн ажлын хэсгийн санал байна. Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн томъёоллоор санал хураалт.

52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Уянгахишиг гишүүн тайлбар өгье.

Г.Уянгахишиг: Энэ дээр 4 дүгээр заалт дээр болохоороо Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэдэг нэр байгаа. Нэр нь болохоор энэ дээр одоо бид нар зөвхөн нэмэлт биш өөрчлөлт оруулж байгаа учраас нэмэлт гэдэг үгийг нь хасъя гэдэг найруулгын шинжтэй санал шүү.

Р.Сэддорж: 4.Төслийн нэрийн нэмэлт гэснийг хасах санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, Уянгахишиг.

Санал хураалт.

63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар хэлэлцэнэ.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

За 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух санал хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Санал хураалт.

Санал хураалтын томъёоллыг уншъя. Төслийн 1 дүгээр 3 зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуульд доор дурдсан агуулгатай 20.18, 20.19 дүгээр зүйл нэмсүгэй.

20.18 дугаар зүйл. Бооцоот таавар зохион байгуулах.

1.Эрх бүхий байгууллагын олгосон зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээс бусад хэлбэрээр оролцогч болон зохион байгуулагчийн аль аль нь үр дүнг нь урьдчилан мэдэх эсвэл үр дүнд нь нөлөөлөх боломжгүй үйл явдлын үр дүнг тааварлаж тогтоосон дүрмийн дагуу бооцоо тавьдаг. Бооцоот тааврыг ашиг олох зорилгоор

олон нийтийн газар болон мэдээллийн технологи ашиглан зохион байгуулсан бол 2700 нэгжээс 14000 мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 240 цагаас 720 цаг хүртэл хугацаатайгаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 3 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ.

20.19 дүгээр зүйл. Мөрийтэй тоглоом бооцоот таавар зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх:

1.Мөрийтэй тоглоом зохион байгуулах эсхүл хууль бусаар бооцоот таавар зохион байгуулах гэмт хэргийн үйлдэлд өөрийн эсхүл бусдын нэр дээрх төлбөр тооцооны данс, цахим мөнгө, виртуал хөрөнгө, харилцаа холбооны сүлжээний дугаар, цахим тодорхойлогчийг удаа дараа ашиглуулах замаар дэмжлэг үзүүлсэн бол 450 нэгжээс 5400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эс үгүй бол 240 цагаас 720 цаг хүртэлх хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх эс үгүй бол 6 сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах эс үгүй бол 6 сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг.

Сайнзориг гишүүн тайлбар хэлнэ.

Саналаа тайлбарлана.

П.Сайнзориг: Баярлалаа дарга аа. Эрүүгийн хуулийн 20.18 дугаар зүйл дээр байгаа олон нийтийн газар болон гэснийг олон нийтийн газар эсхүл гэдэг байдлаар буюу болон гэдгийг эсхүл гэдэг найруулга байдлаар хураагаад өгөөч ээ. Ингэж байж яг гэмт хэргийн шинжийн хувьд эрс тодорхой болох юм. Аль аль нь хангагдаж гэмт хэрэг бүрдэнэ гэх юм бол энэ боломжгүй болчихоод байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бас найруулгын энэ зүйлийг хэлээд би саналыг хураалгахыг хүсэж байна аа.

Сайнзориг гишүүний 20.18 дугаар зүйл дээр болон гэснийг эсвэл гэж үг үг сольж найруулга дээр өөрчлөлт орж байгаа.

Ингээд санал хураалт явуулна.

Төслийн 1 дүгээр зүйлийг өөрчлөн найруулах доор дурдсанаар өөрчлөн найруулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Батсүмбэрэл гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

Уг хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн [Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар](#).

Эрүүгийн хуулийн 2 дугаар зүйл дээр асуулт асууж санал хэлэх гишүүд байна уу.

Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: 2 дугаар зүйл дээр нөгөө хууль хүчин төгөлдөр болох юу байгаа. Хуулийг нөгөө Зөвшөөрлийн хуулийн нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш дагаж мөрдөнө өө гэгчихсэн байгаа. Агуулгын хувьд. Тэгэхээр энэ дээрээс нөгөө нэмэлтийг нь хасаж байгаа учраас Эрүүгийн хуулийн тэр 2 дугаар зүйлийн нэмэлт таслал гэснийг хасах зарчмын зөрүүтэй санал гаргаж байна аа. Хурааж өгнө үү. Дэмжиж өгөхийг хүсье.

Р.Сэддорж: Сайнзориг гишүүний саяын уншсан томъёоллоор зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт.

Зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт.

63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уг хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух үг хэлэх гишүүд байна уу.

1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 10.1 дүгээр зүйлийн 6.7 дахь хэсгийн төлбөрт таавар эс үгүй бол бооцоот тоглоом гэснийг мөрийтэй тоглоом эс үгүй бол хуулиар зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бооцоот тааврыг гэж тус тус өөрчлөх ийм санал ажлын хэсгээс гаргасныг ажлын хэсгээс хуулиар зөвшөөрснөөс бусад хэлбэрийн гэснийг хасах гэсэн саналыг ажлын хэсгийн гишүүн Сайнзориг гаргасан байна.

Ингээд энэ томъёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

Батсүмбэрэл гишүүн горимын санал гаргана.

Н.Батсүмбэрэл: Лодойсамбуу гишүүн бид 2-ын төхөөрөмж ажилласангүй ээ. Дахиж санал хураалт явуулж өгнө үү.

Р.Сэддорж: Батсүмбэрэл гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн горимын саналаар санал хураалт.

52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалтыг дахин явуулъя.

Санал хураалт.

Соронзонболд гишүүн горимын санал гаргах гэсэн юм. Саяын санал хураалтыг хүчингүй болгож өгөх санал хураалтыг зохион байгуулж өгөөч.

Р.Сэддорж: Сүүлийн санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн Соронзонболд гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт.

57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн [Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар](#).

Төслийн 1 дүгээр зүйл буюу 10.1 дүгээр зүйлийн 6, 7 дахь хэсгийн “Төлбөрт таавар, эсхүл бооцоот тоглоом” гэснийг “Мөрийтэй тоглоом, эсхүл хуулиар зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бооцоот тааврыг” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг.

Санал хураалт.

Батшугар гишүүн.

Батшугар гишүүний микрофоныг.

Э.Батшугар: Сая саналаа өгсөн юм. Тэгээд төхөөрөмж хурууны хээг уншсангүй. Тэгээд горимын санал гаргаж саяын саналыг хүчингүй болгоно уу гэсэн горимын санал гаргаж байна аа. Баярлалаа.

Р.Сэддорж: Батшугар гишүүний гаргасан санал хураалтыг хүчингүй болгох гэсэн горимын саналаар санал хураалт.

52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалт хүчингүй болж байна.

Санал хураалтыг дахин явуулъя. Анхааралтай.

Гишүүд анхааралтай санал хураалтад оролцоорой.

Төслийн 1 дүгээр зүйл буюу 10.1 дүгээр зүйлийн 6, 7 дахь хэсгийн “Төлбөрт таавар, эсхүл бооцоот тоглоом” гэснийг “Мөрийтэй тоглоом, эсхүл хуулиар зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бооцоот тааврыг” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг.

Санал хураалт.

52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн нэмэлт гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, Уянгахишиг.

Энэ зүйл дээр асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Ингээд төслийн 2 дугаар зүйлийн нэмэлт гэснийг хасах саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

Санал хураалт хэлэлцүүлэг хийгдэнэ. Ингээд төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу? Асуулт саналтай гишүүд байна уу? 1 дүгээр зүйлтэй холбогдуулж Сайнзориг гишүүн санал гаргаж байна.

Р.Сэддорж: Нэр томьёоны ойлгомжтой байдал Эрүүгийн хуульд орж байгаа өөрчлөлттэй холбоотойгоор “төлбөрт таавар, эс үгүй бол “бооцоот тоглоом” эсвэл “мөрийтэй тоглоомыг” гэснийг “мөрийтэй тоглоом” эс үгүй бол “бооцоот тааврыг” гэж өөрчлөх ийм зарчмын зөрүүтэй санал гаргаж байна.

1 дүгээр зүйл дээр дэмжиж өгөхийг хүсье. Сайнзориг гишүүний гаргасан 1 дүгээр зүйлтэй холбогдуулж гаргасан санал дээр асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. Лодой гишүүн.

Ингээд санал хураалт явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн “төлбөр таавар эс үгүй бол бооцоот тоглоом эс үгүй бол мөрийтэй тоглоомыг гэснийг мөрийтэй тоглоом эс үгүй бооцоот тааврыг гэж өөрчлөх санал гаргасан.

Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг.

Санал хураалт.

57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Асуулт алга байна, санал алга байна.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж санал хураалт явуулъя.

Төслийн 2 дугаар зүйлийн “нэмэлт,” гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг.

Санал хураалт.

52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж санал

гаргах гишүүд байна уу? Асуулт алга байна. Уянгахишиг гишүүн 1 дүгээр зүйл дээр санал гаргасан байна.

Уянгахишиг гишүүн саналаа тайлбарлая.

Г.Уянгахишиг: Хувь хүний орлогын албан татварын уу Онцгой аан за. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа.

Тэгэхээр яах вэ? Уг нь энийг бол нөгөө ХЗБХ-н дээр хэлэлцээгүй учраас энд Эдийн засгийн байнгын хороон дээр зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа юм шүү. Тэгэхээр санал хураалгах болж байгаа үндэслэл болохоор Зөвшөөрлийн тухай хууль болон Эрүүгийн хуульд оруулж байгаа өөрчлөлтийн дагуу нэр томъёог нийцүүлэх шаардлагатай байгаа.

Төлбөрт таавар, бооцоот тоглоомыг эрхлэхэд шаардагддаг онцгой албан татвар ногдуулах бараа, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нэр төрлөөс спорт, бооцоо, тааврыг эрхлэх шаардлагатайгаас бусад барааг нь хасах гэдэг утгаараа саналын томъёолол орж ирсэн.

1 дүгээр зүйл дээр Онцгой албан татварын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн төлбөрт таавар бооцоот тоглоомын гэснийг спорт, бооцоо, тааврын гэж 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсгийн төлбөрт таавар, бооцоот тоглоомын гэснийг Спорт, бооцоо, тааврын гэж, 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн 3, 4 дэх заалтын дугаарыг 1, 2 гэж тус тус өөрчилсүгэй.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг.

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1 дүгээр зүйл. Онцгой албан татварын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “төлбөрт таавар, бооцоот тоглоомын” гэснийг “спорт, бооцоот, тааврын” гэж, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсгийн “төлбөрт таавар, бооцоот тоглоомын” гэснийг “Спорт бооцоот тааврын” гэж, “5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн 3.4 дэх заалтын дугаарыг” “1.2” гэж тус тус өөрчилсүгэй. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг.

Санал хураалт 47.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүд байна уу? Асуулт алга байна.

Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн томъёололтой санал гаргасан байна. Уянгахишиг гишүүн саналаа тайлбарлая.

Г.Уянгахишиг: Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хасаж байгаа. Энэ нь Зөвшөөрлийн тухай болон

Эрүүгийн хуульд оруулж байгаа өөрчлөлтийн дагуу нэр томьёонд нийцүүлэх зорилгоор энэ 2 дугаар зүйлийг хасаж байгаа шүү. Нэр томьёо жигдлэх.

Төслийн 2 дугаар зүйлийг хасахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

36.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж санал гаргах, асуулт асуух гишүүд байна уу? Асуулт алга байна.

Саналын томьёолол. Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчилсүгэй:

2 дугаар зүйл. Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг* 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн 1.2 дахь заалтыг тус тус хүчингүй болгосонд тооцсугай.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг. Уянгахишиг гишүүн саналаа тайлбарлая.

Г.Уянгахишиг: Онцгой албан татварын тухай хуулийн 5.4, 6.4 дээр болохоор нөгөө тоглоомын хүрд, тоглоомын нөгөө слот машин эд нарыг дурдаад өгчихсөн байдаг. Тэгэхээр угаасаа мөрийтэй тоглоом бол хоригдчихсон. Тийм учраас яг тэрэнд ашиглагддаг энэ 2-ыг бол хасах ёстой гэдгээр Онцгой албан татварын тухай хуулиас энэ 2 заалтыг 2 хэрэгслийг заалтыг хасаж байгаа юм. Харин тэр нөгөө спорт бооцоо таавартай холбоотой нь бол татвараа төлөөд явах ёстой. Тэгэхээр Татварынхаа хууль дотроо байх ёстой гэдгээр өөрчлөлт орж байгаа шүү.

Р.Сэддорж: Уянгахишиг гишүүний гаргасан саналаар саналын томьёоллоор дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух, санал гаргах гишүүд байна уу? Жаргалан гишүүн асуулт.

Б.Жаргалан: Энэ асуудал дээр нөгөө намын бүлэг дээр саналаа нэгтгэх шаардлагатай байгаа учраас завсарлага авъя. Санал хураалтуудыг зогсоогоод.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйл. Хуралдаанаас завсарлага авах.

12.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол нам эвслийн бүлэг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30.1.5-д заасны дагуу завсарлага авах эрхтэй. Завсарлага авах хугацаа ажлын 5-аас илүүгүй өдөр байх бөгөөд шаардлагатай бол нам эвслийн бүлгийн хүсэлтээр хуралдаан даргалагч завсарлагын хугацааг нэг удаа ажлын 3-аас илүүгүй өдрөөр сунгаж болно.

12.2.Нам, эвслийн бүлгийн дарга, түүний эзгүйд дэд дарга энэ хуулийн 12.1-д заасны дагуу завсарлага авахдаа үндэслэл хугацааг тодорхой хэлж энэ талаар хуралдааны тэмдэглэлд тусгуулна гэсэн байна.

Өдрөө тодорхой хэлэх юм байна. Үндэслэлээ тодорхой хэлэх юм байна. Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Бид бүлэг дээрээ саналаа нэгтгэх шаардлагатай байгаад байгаа учраас 5 хоног завсарлага өгнө үү?

Р.Сэддорж: Энэ бол яг өнөөдрийн санал хураалтаас цааш ингээд үргэлжлэхээр завсарлага авч байгаа.

Өмнөх санал хураалтууд хүчинтэй гэсэн үг.

Ингээд Улсын Их Хурал дахь АН-ын бүлгээс гаргасан бүлгийн дэд даргын гаргасан хүсэлтээр 5 хоногийн завсарлага энэ асуудал дээр авч байна.

13.43 цагт

Ингээд хэлэлцэх асуудал 3.

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж эхэллээ.

Хуулийн төсөл болон тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг 2025 оны 4 дүгээр сарын 25, 5 дугаар сарын 2-ны өдрүүдийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулсан бөгөөд чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг тусгасан төслийн эцсийн хувилбарыг та бүхэндээ тараасан байгаа.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Монголбанкны дэд ерөнхийлөгч Энхтайван, СЗХ-ны ББСБ-ын газрын дарга Итгэлсүрэн, Монгол банкны Санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал Мөнх-Ундрах.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгаас асуух асуулттай Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү. Гишүүд алга байна.

Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 3 саналын томъёоллыг Байнгын хорооноос санал хураалгаж шийдвэрлүүлэхээр чуулганы нэгдсэн хуралдаанд оруулсан.

Байнгын хорооны гишүүдийн олонхын санал авч дэмжигдсэн нэг санал. дэмжигдээгүй 2 саналын томъёолол оруулсан. Хуралдаанаар эдгээр 3 саналыг хэлэлцэх үед Байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжсэн боловч Байнгын хорооны дэмжээгүй саналуудыг дэмжээгүйгээс 2 санал босож хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг дээр зарчмын зөрүүтэй 3 зэрэгцээ саналын томъёололтой

болсон. Иймээс энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд эдгээр саналуудаар дахин санал хураалт явуулахаас аргагүй болсон байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн дараах зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхэлье ээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дэмжсэн саналыг Байнгын хорооноос дэмжсэн санал гэж үзэн чуулганы нэгдсэн хуралдаанд оруулна аа.

Саналыг уншиж танилцуулъя.

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж заасны дагуу хураалгах санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

14.3.олон улсын жишиг, зарчмыг баримтлан Монголбанкнаас баталсан нөхцөл, шаардлагыг үндэслэн энэ хуулийн 14.1.3-д заасан зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэл, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг тогтооно.

Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

14.3.зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэлийг Монголбанкнаас заасан зарчмыг баримтлан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд тогтооно.

Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг бүхэлд нь хасах.

Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Тэгээд эхний саналаар санал хураалт явуулна.

Эхний санал 3-ны 2-оор дэмжигдвэл санал хураалт цаашаа үргэлжилнэ.

Санал хураалт.

14.3.Олон улсын жишиг, зарчмыг баримтлан Монголбанкнаас баталсан нөхцөл, шаардлагыг үндэслэн энэ хуулийн 14.1.3-д заасан зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэл, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг тогтооно.

Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Санал хураалт.

73.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Алдаржавхлан гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

Хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж дууслаа.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл буюу Зээлийн мэдээллийг хадгалах хугацааг 5, 5 жил байх санал анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн бөгөөд хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн 1 дүгээр зүйлд уг хугацааг зургаа хүртэлх жил байхаар тусгасантай зөрчилдөж байгаа.

Иймээс энэ зөрчлийг шийдвэрлэхийн тулд чуулганы нэгдсэн хуралдаанаар тогтоолын төслийн 1 дүгээр зүйлтэй холбоотой саналыг хэлэлцсэн болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн дараах зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхэлье ээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дэмжсэн саналыг Байнгын хорооны дэмжсэн санал гэж үзэн чуулганы нэгдсэн хуралдаанд оруулна аа.

Саналыг уншиж танилцуулъя.

“Хууль баталсантай холбогдуулан авах зарим зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь санал хураалгах шаардлагатай гэж заасны дагуу хураалгах санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 хүртэлх гэснийг 5 гэж өөрчлөх санал гаргасан Эдийн засгийн байнгын.

Санал хураалт 68.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Батшугар гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

Тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж дууслаа.

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал уншиж танилцуулна аа.

13.55 цагт

Дараагийн асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал 4.

Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг хэлэлцэж эхэлье ээ.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарах Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтэд хийсэн дүн шинжилгээний тайланг та бүхэнд тараасан байгаа.

Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний үндэсний хорооны дарга Эрдэнэбилигийн Одбаярыг мэдээллээ танилцуулахыг урьж байна.

Сайдын микрофоныг нээе. 5 номер.

Э.Одбаяр: Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амрыг эрж мэндчилье ээ.

Засгийн газар дахь Хяналтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4-д хууль, тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлан, мэдээлэл ирүүлэх явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа үр дүнг үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулж, Засгийн газарт танилцуулах гэж заасныг үндэслэн хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг танилцуулж байна аа.

Яам, аймаг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд ирүүлсэн хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн тайланд үндэслэн хяналт, шинжилгээ, үнэлгээг хийсэн бөгөөд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, нийтлэг журмын 6.3-д заасан аргачлалыг баримталсан болно.

Мөн Засгийн газрын 206 дугаар тогтоолын 8.5-д ЗГХЭГ хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явцад хагас бүтэн жилээр хяналт шинжилгээ хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулан холбогдох тайланг Улсын Их

Хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, ҮАБЗ-ийн Ажлын албанд тус тус хүргүүлнэ гэж заасны дагуу 2025 оны 2 дугаар сарын 28-ны өдөр ЗГХЭГ-аас Улсын Их Хурлын Тамгын газарт хүргүүлсэн.

Монгол Улсын хууль Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын Байнгын хорооны шийдвэрийн хэрэгжилт, Засгийн газрын хяналт шинжилгээ үнэлгээний мэдээллийн цахим санд Монгол Улсын 89 хууль, Улсын Их Хурлын 104, Улсын Их Хурлын байнгын хорооны 79, нийт 272 шийдвэрийн 1550 заалт бүртгэлтэй байгаа бол хэрэгжилт нь дунджаар 66.4 хувьтай байна аа.

Энэ нь өмнөх оны мөн үеэс 3.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна аа.

Үүнээс Эдийн засгийн байнгын хорооны дангаар гаргасан 9 шийдвэр, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороотой хамтран гаргасан нэг шийдвэр нийт 10 шийдвэрийн хэрэгжилт дунджаар 78.8 буюу хэрэгжих шатандаа гэж үнэлэгдсэн байна аа. Ингээд энэ жилээс эхлээд энэ хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг Байнгын хороо тус бүрээр гаргасан шийдвэрийнх нь Засгийн газартай хамаатай хэсгийг үүрэг даалгавар болгосон хэсгийг тайлангийн дэлгэрэнгүй гаргадаг болсон байгаа. Тэгээд тайлангийн дэлгэрэнгүйг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дарга Өнөрбаяр танилцуулна.

Р.Сэддорж: 4 номер Өнөрбаяр дарга.

Ажлын хэсгийн 4 номер.

Ч.Өнөрбаяр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн энэ өдөр амар амгаланг айлтгая.

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар Улсын Их Хурлын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд бол хяналт шинжилгээ үнэлгээ хийгээд 2024 оны жилийн эцсийн тайланг танилцуулж байгаа тэгээд энэ хийх үндэслэл маань манай Хяналт хэрэгжүүлэх Газрын тухай хуулийн 17.1.4 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор гарсан журмын дагуу үнэлдэг ээ. Энэний дагуу бол Монгол Улсын нийт 89 хуулийн 481 заалт, Улсын Их Хурлын 104 тогтоолын 624 заалт, Улсын Их Хурлын байнгын хорооны 79 тогтоолын 445 заалт, нийт 272 шийдвэрийн 1550 заалтыг Үнэлгээ мэдээллийн нэгдсэн санд байгаа тэр хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Хяналт шинжилгээ, үнэлгээний нэгдсэн санд байгаа Улсын Их Хурал болон Улсын Их Хурлын Байнгын хорооны шийдвэрийн үнэлгээний ангиллаар нь авч үзэх юм бол 569 буюу 36.7 хувь нь бүрэн хэрэгжсэн, 390 буюу 25.2 хувь нь хэрэгжилтийн шатандаа, 224 буюу юу 14.5 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 196 буюу 12.6 хувь нь хэрэгжээгүй гэж дүгнэгдсэн байна аа.

Харин хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй гэсэн үндэслэлээр 170 заалт үнэлэх боломжгүй байсан. Ингээд дунджаар хэрэгжилт 66.4 хувьтай байгаа. Улсын Их Хурлын Байнгын хорооны шийдвэрийн биелэлтийг бол дэлгэрэнгүй байдлаар гаргасан.

Энийг та бүхэнд тараагдсан учраас эндээс та бүхэн асуувал би хариулъя аа. Яг энэ дотроос Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны тогтоолтой

холбоотой юман дээр нарийвчилж хэлэх юм бол хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй байгаа Эдийн засгийн байнгын хорооны дангаар гарсан 9 шийдвэр, Аюулгүй байдал, гадаад байнгын хорооны тухай хамтарсан 1, нийт 10 шийдвэрийн дунджаар 78.8 хувьтай байгаа. Өөрөөр хэлбэл хэрэгжилтийн шатдаа байгаа гэж гарсан байна. Эдийн засгийн байнгын хорооноос Засгийн газарт чиглэл өгсөн үнэлгээний хэрэгжилтийг бол бид нар бол гаргасан байж байгаа. Энийг дэлгэрэнгүйгээр Байнгын хорооны гишүүдэд тараасан учраас та бүхэн энэ дээр танилцаад асуувал хариулъя аа.

Ер нь бол нэмэлт мэдээлэл өгөхөд Засгийн газар дээр энэ үнэлдэг үнэлгээний журам бол зөвхөн арга хэмжээнүүдийг үнэлж ирсэн. Тэгээд энэнээсээ болоод үр дүн, үр ашиг нь хаанаа байгаа юм бэ? Нөгөө төсөв нь тавигдсан юм уу? Хэрэгжих юм нь байгаа юм уу гэдэг асуудал гараад энэ асуудал дээр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас 3 журмын төслийг боловсруулаад Засгийн газрын хуралдаанаар батлуулсан. Тэгээд одоо энэ 3 журам бол 5 сарын 1-ээс эхлээд мөрдөгдөхөөр байгаа. Энэ 3 журмын дагуу бол зөвхөн арга хэмжээ үнэлдэг биш. Тодорхой хийсэн ажлуудыг үр дүнг нь үнэлдэг болж байгаа. Тэгээд энэ дээр бол бас ирэх жил бол энэ шинэ 3 журмын дагуу бол үнэлж орж ирж бас тодорхой хэмжээний өөрчлөлтүүд гарах байх гэж бодож байна.

Тэгээд эцэст нь санал, дүгнэлтээ дамжуулъя.

Тэгээд ер нь яах вэ зарим зүйл заалт нь хэрэгжихгүй байгаа яагаад хэрэгжээгүй шалтгаан нь юу юм бэ гэж бид нар судалж үзсэн дээ ер нь яах вэ төрийн захиргааны төв байгууллагууд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнахдаа зөвхөн харьяа байгууллагын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг нэгтгэн тайлагнахгүй, яамны хэмжээнд хэрэгжүүлсэн арга хэмжээгээ тайлагнаад байгаа нь бол өөрөө энэ хэрэгжилт нь бүрэн дүүрэн тодорхой гарахгүй байх нь нэг үндэслэл болж байна гэж харж байгаа. Мөн Улсын Их Хурлын тогтоол болон мөн Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт чиглэл, үүрэг өгсөн шийдвэр гарсан. Гарсан тухай бүр нь Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлэхгүй байгаагаас ч зарим шийдвэрийг шийдвэрийг тухай бүр цахим системд хяналтад бүртгэх боломжгүй байдал байсаар байсан.

Тухайлбал өнгөрсөн жил Улсын Их Хурлын 2024 оны 1 сард баталсан нэг тогтоол, 12 сарын 19-нд хяналт хэрэгжүүлэх газарт ирсэн гэх юм уу даа цахим системд бүртгэгдэж. Гэтэл 12 сарын 25-ны өдөр бид нар хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ёстой байдаг. Ингээд цаг нь тулчихсан ийм тохиолдлууд гарч байсан.

Тэгэхээр цаашдаа бол энэ Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хороодын гаргасан шийдвэрийг цаг алдахгүй бас хүргүүлдэг байх юм бол бид нар энэ бүгдээрээ хэрэгжилтийн үнэлгээг нь хийгээд та бүхэнд цаг алдалгүй мэдээлэл өгдөг юм руу орох ёстой гэж харж байгаа.

Мөн холбогдох байгууллагууд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнахдаа өмнөх тайлант хугацааны биелэлттэй харьцуулан үзэж хүрсэн үр дүнг огт тайлагнаагүй ээ. Утга агуулгын хувьд алдаатай тайлагнах мөн өмнөх оны хэрэгжилтийг хуулбарлан давтан тайлагнасан, өөрийн үнэлгээг бодитой үнэлээгүй байсан систем нийтлэг алдаанууд байсан гэдгийг хэлье. Тэгээд цаашдаа бол Улсын Их Хурал болоод Улсын Их Хурлын холбогдох Байнгын хорооноос Засгийн газар болоод Засгийн газрын харьяа байгууллагууд холбогдох хууль,

тогтоомжоор үүрэг чиглэл өгсөн шийдвэрлэлтийг богино хугацаанд бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах, дотоод хяналтыг сайжруулж чиглэлээр чиглэл өгөөсэй гэж хүсэж байгаа.

Мөн Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг чиглэл өгсөн шийдвэр гарсан тухай бүр шийдвэрийг Засгийн газрын хяналт зохицуулах газарт хүргүүлж байхыг холбогдох албан тушаалд нь уламжилж шийдвэрлүүлбэл бидний ажилд сайн байгаа. Тэгээд нөгөө талаасаа бид мэдээж Улсын Их Хурлынхаа Байнгын хорооны гаргасан шийдвэрийг цаг тухайд нь хэрэгжүүлээд хэрэгжилтийнх нь мэдээ тайланг үнэлж дүгнэж байгаад гаргачихвал энэ маш тустай байгаа. Эцэст нь хэлэхэд Хяналт шинжилгээ үнэлгээний үр дүнд үндэслэн бүрэн хэрэгжсэн чиг үүрэгт хамааралгүй болсон шийдвэр хүчингүй болсон, дахин шийдвэр гарсан, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон зэрэг нийт 519 заалтыг Засгийн газрын хяналт шинжилгээ үнэлгээний мэдээллийн нэгдсэн сангаас хасуулах тийм хүсэлтийг оруулж байгаа гэдгийг хэлье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя.

Одбаяр Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Улсын Монгол Улсын сайд Хяналт үнэлгээний үндэсний хорооны дарга, Өнөрбаяр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга, Үүрийнтуяа Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын үнэлгээ, мониторингийн газрын дарга, Отгонцэцэг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын үнэлгээ, мониторингийн газрын хууль, тогтоомж, тогтоол шийдвэр хариуцсан ахлах референт, Бумаажав Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын хууль, тогтоомж тогтоол шийдвэр хариуцсан референт.

Сайдын мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Соронзонболд гишүүнээр тасаллаа. Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд асуулт асууж, үг хэлнэ.

Л.Соронзонболд: Энэ тамгын газрын хяналтаас хасах саналтай шийдвэрийн жагсаалтыг ямар үндэслэлүүдээр гаргасан бэ гэдэг асуулт байгаад байна.

Өөрөөр хэлбэл Их Хурлын тогтоол, Байнгын хорооны тогтоол, хуулийн хэрэгжилттэй холбоотой гээд энэ хүснэгт бол нэлээн олон хүснэгт байна л даа. 46 хуудас. Тэгэхээр эдгээрийг хасах саналыг гаргахдаа ямар үндэслэл баримталж ажилласан бэ гэдэг ийм асуулт байна.

Р.Сэддорж: 4 номер хариулт.

Ч.Өнөрбаяр: Гишүүний асуултад хариулъя аа.

Нэгдүгээрт бол яах вэ энд зарим нь бол бүрэн хэрэгжсэн байгаа. Тэгэхдээ нөгөө систем дээр байгаад байгаа учраас ингээд нэг үнэлэх ёстой болчхоод байдаг.

Зарим нь бол төсөв батлагдсантай холбоотойгоор байхгүй болчихсон зүйл байгаа. Зарим нь огт хэрэгжээгүй гээд тийм хэрэгжээгүй зүйлүүд байгаа. Өөрөөр хэлбэл энэ нь дандаа цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болчихсон. Өмнө нь баталсан боловч одоо бол ямар ч хэрэгжүүлэх цаг хугацааны болоод үр ашгийн хувьд боломжгүй өөр шийдвэр гарчихсан. Жишээлбэл журам гаргана гэхийсэн байж байтал тэрэн дээр холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулчихсан ч гэдэг юм уу ийм тохиолдлууд байгаад байгаа. Тэгээд энэ дээр бол Улсын Их Хурлын Тамгын газар дүн шинжилгээ хийгээд ТББХ-н дээр би нэгдсэн байдлаар энэ хасах заалтуудыг танилцуулна гэж ойлгож байгаа. Ер нь бол гишүүний асуултад хариулахад зарим нь бүрэн дүүрэн хэрэгжээд дуусчихсан, зарим нь цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болчихсон. Зарим нь төсөв дээр суугдаагүй. Зарим нь бол яг анх өгсөн шийдвэрээсээ өөр байдлаар шийдэгдчихсэн, зарим нь бол үр өгөөжгүй болчихсон байна гээд ингээд янз бүрийн үндэслэлүүд байгаа юм аа. Тэгээд энэ дээр бол бид нар аль болохоор нөгөө байж болох үндэслэлээр нь л гаргаж тавьсан.

Тэгээд энийг хасахгүй бол цаашаа нөгөө үнэлгээгүй, үнэлэхэд ач холбогдолгүй зүйл болчихоод байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Р.Сэддорж: Соронзонболд гишүүн тодруулъя.

Л.Соронзонболд: Одоо ингээд нөгөө нэг юу Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний шийдвэрийн биелэлт хангалтгүй байна гээд гараад байгаа. Тэгэхээр энэ ер нь цаашдаа энэ хангалтгүй байгаа хувийг ер нь сайжруулахын тулд ямар арга хэмжээг зайлшгүй авах шаардлагатай гэж үзэж байна вэ? Зарим нэг байгууллагуудын гүйцэтгэл 100 хувьтай, зарим байгууллага наяд хувьтай гээд л янз бүр л байна л даа. Тэгээд ингээд хараад үзэхээр ерөнхий биелэлт Их Хурлын тогтоолын биелэлт 49.5 хувьтай эд нар гээд ийм байдалтай байгаа. Тэгэхээр ер нь цаашдаа энэ олон жагсаалтуудыг бүгдийг нь ингээд яг системтэй зөв хянадаг болохын тулд ямар арга хэмжээ авах ёстой гэж харж байгаа вэ?

Р.Сэддорж: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Гишүүний асуултад хариулъя.

Ч.Өнөрбаяр: Ер нь бол 1992 оны Үндсэн хууль батлагдсанаас хойш анх удаагаа 30 жилд Улсын Их Хурал Улсын Их Хурлын Байнгын хорооны гаргасан шийдвэрийн биелэлтийг гаргаж танилцуулдаг болж байгаа. Тэгээд бол энэ дээр ингээд хараад байхад яах вэ жишээлбэл зарим чиг үүрэг нь буруу өгөгдчихсөн тохиолдлууд гардаг.

Өөрөөр хэлбэл харьяаллын биш байдлаар үүрэг чиглэл өгөгдчихсөн. Энэнээсээ болоод хэрэгжихгүй тохиолдол гардаг. Тэгээд энэн дээр бол бас бид нар дүн шинжилгээ хийгээд мэдээллээр хангая гэж ярьж байгаа юм. Нөгөө талдаа яах вэ Засгийн газрын түвшинд таны хэлээд байгаатай үнэхээр санал нэг байна аа.

Энийг Монгол Улс төлөвлөлт, төсөвлөлт, гүйцэтгэлийн хяналт гурваа нэг болгохгүй бол энэ 3 нь нэг бишээс болоод мэдээллийн зөрүү гараад хаанаа юу төлөвлөснийг нь төсөвлөлд нь төсөв нь тавигддаггүй эсвэл төсөвлөлт нь өөрөө үр дүн хяналттайгаа уялдахгүй байгаа даа. Энийг нэг болгохын тулд Засгийн газар дээр бол олон улсын үнэлгээний цогц систем буюу ди эм системийг нэвтрүүлъя гээд. Ингээд 2025-нд гол зорилго болгоод.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж үг хэлж дууслаа.

Сайдын мэдээлэлтэй танилцаж дууссан.

Ингээд Эдийн засгийн байнгын хорооны өнөөдөр хэлэлцэх асуудал дууссан. Хуралдаан үүгээр өндөрлөж байна аа. Идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

14.08 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА